



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 26 өдөр

Дугаар A/114

Батноров сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн журам)-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн малын хөлийн албан татвараар хэрэгжүүлж буй "Багуудад бодын тарилгын хашаатай болох" ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заагдсан хугацаанд тус ажлыг бүрэн гүйцэд хийлгэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Жаргалцэцэг	(Мал эмнэлгийн тасгийн дарга)
Гишүүд:	Г.Цолмонтуяа	(Соёл сангийн нягтлан бодогч)
	Б.Мөнх-Эрдэнэ	(Татварын улсын байцаагч)
	Ч.Чинхүсэл	(ХААТасгийн мэргэжилтэн)
	Н.Энхтайван	(Иргэний төлөөлөл)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, явцын чанар, ажлын тоо хэмжээ, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагч байгууллагыг бүрэн төлөөлж хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулан удирдлагыг мэдээллээр хангаж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, явцын дүгнэлт, гүйцэтгэлд акт үйлдэн тус ажлыг бүрэн хүлээж авах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР